



БУЛГАН АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 1/03

Булган сум

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон  
сунгах, үйл ажиллагааны чиглэл нэмэх,  
хүчингүй болгох тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, “Зөвшөөрлийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 8.1 дүгээр зүйлийн 13 дахь заалт, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3.5, 19.18, 19.20.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400, 2022 оны А/480 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/654 дугаар захирамж, “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын 2023 оны 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгах, үйл ажиллагааны чиглэл нэмэх, хүчингүй болгох Эрүүл мэндийн байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох хууль тогтоомж, тушаал, журмыг баримтлан хяналт тавьж, зөрчил дутагдал үүсэхээс сэргийлэх, үүссэн даруйд холбогдох арга хэмжээ авч ажиллахыг комиссын Нарийн бичгийн дарга (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

3. Хууль тогтоомж, тушаал, журмыг баримтлан ажиллахыг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

С.НАРАНТУЯА



Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны  
 01 дүгээр сарын 20 -ны өдрийн  
 4/03 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
 ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Тусгай зөвшөөрөл эхлэх хугацаа	Тусгай зөвшөөрөл дуусах хугацаа
1	Орхон сумын ЭМТ	5 жилээр	2023.01.24	2028.01.24
2	Хялганат тосгоны ЭМТ	5 жилээр	2023.01.24	2028.01.24
3	"Алтан мана" ХХК-ийн Цагаан уул эмнэлэг	5 жилээр	2023.01.07	2028.01.07

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
 ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрөл дуусах хугацаа	Цуцлах үндэслэл
1	"Мөнхийн тун" ХХК	Булган эмийн сан	2022.07.09	"Эрүүл мэндийн тухай" хуулийн 19 дүгээр зүйлийн 19.20.1 дэх заалт
2	"Эмийн багваахай" ХХК	Эмийн багваахай эмийн сан	2023.01.07	
3	Хишиг-Өндөр "ТУР" ХХК	Сувилал	2022.09.29	
4	"Свинг интернэшнл" ХХК	"Мон Ази" эмийн сан	2022-09-02	

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
 ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВАХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Олгох хугацаа
1	Гурванбулаг сумын "Уянга хулст фарм" ХХК-ны эмийн сан	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах	3 жил

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ НЭМЭХ

№	Байгууллагын нэр	Одоо эрхэлж байгаа үйл ажиллагаа	Шинээр нэмэх үйл ажиллагаа
1	Булган сумын "Сожд" ХХК-ны эмнэлэг	Мэдрэл	Сэтгэц наркологийн тусламж, үйлчилгээ